



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 09 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 09 дүгээр хуралдааныг 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 09 дүгээр хуралдаанаар /2025-05-08/ “Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ын Үнэлгээний ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийн тухай (Хорооны 2025 оны 57 тоот тогтоолыг хэрэгжүүлэх) асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 5 (Тогтоол №97-102, 2025-05-08) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

Зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.2}, 5^{1.1.11} дэх заалт, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/45 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Монгол Улсад Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл”, Цахим хөгжил харилцаа холбооны сайдын 2023 оны А/42 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 106 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 57 тоот “Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай” тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн юм. Энэхүү баталсан 2025 оны 57 тоот (Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт) тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Хорооны даргын 2025 оны А/53 тоот тушаалаар “Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ын Үнэлгээний ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан болно. ХХЗХ-ноос ХХЗХ-2025 /ДҮХХ-СШ-01/ тоот “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэл хугацаанд зарласан. Үнэлгээний ажлын хэсгээс Эрх бүхий сонгон шалгаруулалтад оролцогч нараас тендерийн баримт бичиг, иж бүрдэл материалыг хүлээн авч үнэлгээг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, “Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ын Үнэлгээний ажлын хэсгээс 2025 оны 05 сарын 07-ны өдрийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлтийг боловсруулсан байна.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 09 дүгээр хуралдаанд Хорооны даргын 2025 оны А/53 тоот тушаалаар байгуулагдсан “Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000

МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт"-ын Үнэлгээний ажлын хэсгээс сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын тайлан, дэлгэрэнгүй протокол, хурлын шийдвэр, мэдээлэл судалгаа, үнэлгээний дүн болон Үнэлгээний ажлын хэсгийн 2025 оны 05 сарын 07-ны өдрийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлтийг боловсруулан хэлэлцүүлэв.

ХХЗХ-ны 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн ээлжит 09 дүгээр хуралдаанаар "Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт"-ын Үнэлгээний ажлын хэсгээс сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын тайлан, дэлгэрэнгүй протокол, хурлын шийдвэр, мэдээлэл судалгаа, үнэлгээний дүн болон Үнэлгээний ажлын хэсгийн 2025 оны 05 сарын 07-ны өдрийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлтийг хэлэлцээд, 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн дараах "Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцох тухай" 5 тогтоолыг (Тогтоол №98-102) баталсан болно. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны 57 дугаар тогтоол, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2025 оны А/53 тоот тушаалаар байгуулагдсан "Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт"-ын Үнэлгээний ажлын хэсгийн 2025 оны 05 сарын 07-ны өдрийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлтийг тус тус үндэслэн 2025 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 98 тоот "Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцох тухай" тогтоолыг баталсан болно. Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтаар тус хорооноос зарласан "Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт"-д Юнител ХХК нь 97.14 оноо авсан тул сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, нэгдүгээрт эрэмбэлэгдсэнийг баталгаажуулсугай; 2 дугаар заалтаар Шалгарсан оролцогчоор радио давтамжийн зурвас сонгуулах үйл ажиллагааг эрэмбийн дагуу зохион байгуулж, холбогдох саналыг Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд ажлын 3 хоногийн дотор танилцуулж, шийдвэрлүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэгт даалгасугай; 3 дугаар заалтаар Радио давтамжийн зурвасыг 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 12:00 цагт сонгохыг Юнител ХХК-д мэдэгдсүгэй; 4 дүгээр заалтаар энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай. гэж шийдвэрлэв.
- Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны 57 дугаар тогтоол, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2025 оны А/53 тоот тушаалаар байгуулагдсан "Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт"-ын Үнэлгээний ажлын хэсгийн 2025 оны 05 сарын 07-ны өдрийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлтийг тус тус үндэслэн 2025 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 99 тоот "Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцох тухай" тогтоолыг баталсан болно. Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтаар тус хорооноос зарласан "Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт"-д Мобиком корпораци ХХК нь 96.79 оноо авсан тул сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, хоёрдугаарт

эрэмбэлэгдсэнийг баталгаажуулсугай; 2 дугаар заалтаар Шалгарсан оролцогчоор радио давтамжийн зурвас сонгуулах үйл ажиллагааг эрэмбийн дагуу зохион байгуулж, холбогдох саналыг Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд ажлын 3 хоногийн дотор танилцуулж, шийдвэрлүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэгт даалгасугай; 3 дугаар заалтаар Радио давтамжийн зурвасыг 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 12:00 цагт сонгохыг Мобиком корпораци ХХК-д мэдэгдсүгэй; 4 дүгээр заалтаар энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай. гэж шийдвэрлэв.

- Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны 57 дугаар тогтоол, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2025 оны А/53 тоот тушаалаар байгуулагдсан “Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ын Үнэлгээний ажлын хэсгийн 2025 оны 05 сарын 07-ны өдрийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлтийг тус тус үндэслэн 2025 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 100 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцох тухай” тогтоолыг баталсан болно. Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтаар тус хорооноос зарласан “Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-д Скайтел ХХК нь 93.29 оноо авсан тул сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, гуравдугаарт эрэмбэлэгдсэнийг баталгаажуулсугай; 2 дугаар заалтаар Шалгарсан оролцогчоор радио давтамжийн зурвас сонгуулах үйл ажиллагааг эрэмбийн дагуу зохион байгуулж, холбогдох саналыг Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд ажлын 3 хоногийн дотор танилцуулж, шийдвэрлүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэгт даалгасугай; 3 дугаар заалтаар Радио давтамжийн зурвасыг 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 12:00 цагт сонгохыг Скайтел ХХК-д мэдэгдсүгэй; 4 дүгээр заалтаар энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай. гэж шийдвэрлэв.
- Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны 57 дугаар тогтоол, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2025 оны А/53 тоот тушаалаар байгуулагдсан “Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ын Үнэлгээний ажлын хэсгийн 2025 оны 05 сарын 07-ны өдрийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлтийг тус тус үндэслэн 2025 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 101 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцох тухай” тогтоолыг баталсан болно. Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтаар тус хорооноос зарласан “Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-д Жимобайл ХХК нь 79.59 оноо авсан тул сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, дөрөвдүгээрт эрэмбэлэгдсэнийг баталгаажуулсугай; 2 дугаар заалтаар Шалгарсан оролцогчоор радио давтамжийн зурвас сонгуулах үйл ажиллагааг эрэмбийн дагуу зохион байгуулж, холбогдох саналыг Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд ажлын 3 хоногийн дотор танилцуулж, шийдвэрлүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэгт даалгасугай; 3 дугаар заалтаар Радио давтамжийн зурвасыг 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 12:00 цагт сонгохыг Жимобайл ХХК-д мэдэгдсүгэй; 4 дүгээр

заалтаар энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай. гэж шийдвэрлэв.

- Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны 57 дугаар тогтоол, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2025 оны А/53 тоот тушаалаар байгуулагдсан “Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ын Үнэлгээний ажлын хэсгийн 2025 оны 05 сарын 07-ны өдрийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлтийг тус тус үндэслэн 2025 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 102 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцох тухай” тогтоолыг баталсан болно. Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтаар тус хорооноос зарласан “Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-д Ондо ХХК нь 74.17 оноо авсан тул сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тавдугаарт эрэмбэлэгдсэнийг баталгаажуулсугай; 2 дугаар заалтаар Шалгарсан оролцогчоор радио давтамжийн зурвас сонгуулах үйл ажиллагааг эрэмбийн дагуу зохион байгуулж, холбогдох саналыг Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд ажлын 3 хоногийн дотор танилцуулж, шийдвэрлүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэгт даалгасугай; 3 дугаар заалтаар Радио давтамжийн зурвасыг 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 12:00 цагт сонгохыг Ондо ХХК-д мэдэгдсүгэй; 4 дүгээр заалтаар энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай. гэж тус тус шийдвэрлэв.

Үнэлгээний ажлын хэсэгт тус хуралдаанаар батлагдсан 2025 оны 98 тоот, 99 тоот, 100 тоот, 101 тоот, 102 тоот тогтоолуудын 2 дугаар заалт (Шалгарсан оролцогчоор радио давтамжийн зурвас сонгуулах үйл ажиллагааг эрэмбийн дагуу зохион байгуулж, холбогдох саналыг Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд ажлын 3 хоногийн дотор танилцуулж, шийдвэрлүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэгт даалгасугай), 3 дугаар заалт (Радио давтамжийн зурвасыг 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 12:00 цагт сонгохыг эрэмблэгдсэн нэр бүхий 5 ААН, хуулийн этгээд нарт мэдэгдсүгэй)-ын дагуу заасан хугацаанд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тогтоолын хэрэгжилтийг Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэг, Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга Т.Наранмандах-д тус тус үүрэг болгов.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-05-09